



**“УРЬТАЖ УХААР” УРИАН ДОР ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ 7 ХОНОГИЙН АЯНГ ӨРНҮҮЛЭХ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилт, арга хэмжээний нэр	Төсөв, [сая төг] эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах байгууллага (Хамтран оролцох байгууллага)
	ЗХАБ-ыг хангах зорилго		Зам тээврийн ослоор нас барж буй хүүхдийн тоог “0” болгох.			
	ЗХАБ-ыг хангах зорилтууд		<p>НҮБ-ын мэдээлэл:</p> <p>Дэлхий нийтэд зам тээврийн осол нь үхэл, хүнд гэмтлийн үндсэн шалтгааны нэг болж байна. Жил бүр 1,3 сая хүн нас барж, 50 сая хүн гэмтэж байна. Эдгээрээс 5-29 насны хүмүүс хамгийн гол анхаарал хандуулах зорилтот бүлэг болж байна. Дэлхий нийтэд зам тээврийн ослоор нас барсан 4 хүн тутмын 1 нь явган зорчигч, унадаг дугуйгаар зорчигч байна.</p> <p>НҮБ-ын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2021-2030 онд хэрэгжүүлэх даяарчлалын төлөвлөгөөнд 2030 он гэхэд зам, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын нөхцлийг бүрдүүлж, хүмүүсийн хандлагыг өөрчлөн, тусламж үйлчилгээг сайжруулан зам тээврийн ослоор нас барах, гэмтэх явдлыг 50 хувь бууруулах гол зорилтыг дэвшүүлсэн.</p> <p>“Урьтаж” уриан дор замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 7 хоногийн аянг өрнүүлэх үйл ажиллагааны голлох агуулга нь:</p> <ul style="list-style-type: none"> ▪ НҮБ-ын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” жил бүрийн 7 хоногийн үйл ажиллагааг ДЭМБ-ын зүгээс¹ түнш байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулж байна. Энэ удаагийн аян нь: “Явган зорчигч, унадаг дугуй, нийтийн тээврээр зорчигчийн аюулгүй байдлыг хангах тогтвортой тээвэр”-т чиглэгдэнэ. Уг үйл ажиллагааны үр дүн нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ. 			

¹ Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага

	<ul style="list-style-type: none"> ▪ ДЭМБ-ын оролцоотой зохион байгуулагдаж буй НҮБ-ын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” 7 дугаар 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлэхэд туршлага, мэдээллээ солилцох, нийгмийн сүлжээгээр мэдээлэл, сурталчилгаа явуулах зэрэг түншлэх бүх байгууллагыг урьж оролцуулна. ▪ НҮБ-аас улс орнуудын төр засаг болон түнш байгууллагуудад “Урьтаж ухаарах” нь хамгаас чухал гэж уриалж байна. ▪ Аюулгүй байдал нь дэлхий дээр хэрхэн, яаж хөдөлгөөнд оролцож байна вэ гэдгээ сайтар тунгааж бодохоос эхэлнэ. ▪ Аюулгүй байдлыг хангахын тулд авто замын сүлжээний хамгийн эрсдэлтэй байдлыг харгалзан төлөвлөнө. ▪ Аюулгүй байдлыг хангасан нөхцөлд алхах, дугуй унах нь хүмүүсийг эрүүлжүүлэх, хотын хөдөлгөөнийг тогтвортой байлгах, нийгмийг тэгш эрхтэй болгоход хувь нэмрээ оруулж чадна. ▪ Аюулгүй, хямд, хүртээмжтэй, тогтвортой нийтийн тээвэр нь нийгмийн олон асуудлыг шийдвэрлэх арга зам юм. 					
1	<p>НҮБ-ын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” жил бүрийн 7 хоногийн үйл ажиллагааг ДЭМБ-ын зүгээс түнш байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулж байна. Энэ удаагийн аян нь: “Явган зорчигч, унадаг дугуй, нийтийн тээвэрээр зорчигчийн аюулгүй байдлыг хангах тогтвортой тээвэр”-т чиглэгдэнэ. Уг үйл ажиллагааны үр дүн нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ.</p>					
1.1.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах “Урьтаж Ухаар” сэдэвт 7 хоногийн аян эхэлж байгааг нийтэд зарлах хэвлэлийн хурлыг зохион байгуулах	1 сая	Хэвлэлийн хурал хийгдсэн байна.	Аян өрнүүлэх бэлтгэл ажил хангагдсан байна.	2023.05.15.	ЗХАБҮЗАА (ДЭМБ ТЦА НТГ Олон нийтийн байгууллага)
1.2.	ЗХАБ-ын (явган зорчигч, дугуйгаар зорчигч, нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч) талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах	-	Хэлэлцүүлэг хийгдсэн байна.	Бэлтгэл ажлыг хангах	2023.05.16.	МҮОНРТ (ЗХАБҮЗ ТЦА НТГ)
1.3.	Нийтийн тээвэр эрхлэгч байгууллагуудын жолооч нарт аяны үйл ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах	-	Богино хэмжээний сургалтын хөтөлбөрийг бэлтгэж, байгууллага тус бүрт сургалт зохион байгуулсан байна.	Нийтийн тээврийн үйлчилгээний жолооч нарын 80-аас багагүй хувийг сургалтад хамруулж, зохих мэдээлэл өгсөн байна.	2023.05.15-21	ЗХАБҮЗАА (НТГ ТЦА)

1.4.	Нийтийн тээвэр эрхлэгч байгууллагуудын тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдлын үзлэгийг зохион байгуулж, зөвлөмжийг хүргүүлэх		Тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийг зохион байгуулсан байна.	Техникийн үзлэгийн үр дүнд илэрсэн зөрчил, гологдлыг шийдвэрлэсэн байна.	2023.05.15-21	НТГ ТЦА
1.5.	Иргэдийг автомашины хэрэглээнээс татгалзаж, нийтийн тээврээр зорчих, хөдөлгөөнд оролцохыг сурталчлах ажлыг зохион байгуулах		Мэдээлэл, сурталчилгаа хийгдсэн байна.	МҮОНРТ-ээс гадна бусад ТВ, ФМ, сонин, нийгмийн сүлжээгээр сурталчилгааны мэдээлэл явуулна.	2023.05.15-21	ЗХАБҮЗАА (МҮОНРТ НТГ ТЦА)
2	ДЭМБ-ын оролцоотой зохион байгуулагдаж буй НҮБ-ын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” 7 дугаар 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлэхэд туршлага, мэдээллээ солилцох, нийгмийн сүлжээгээр мэдээлэл, сурталчилгаа явуулах зэрэг түншлэх бүх байгууллагыг урьж оролцуулна.					
2.1.	Нийгэмд нэр нөлөө бүхий хүмүүсээр замын хөдөлгөөний сахилга батын талаар мэдээлэл бэлтгэж нийтэд хүргэх		Мэдээлэл бэлтгэсэн эсэх	Мэдээллийг бэлтгэж олон нийтэд хүргэсэн байна.	2023.05.15-21	ЗХАБҮЗАА (ДЭМБ ТЦА)
2.2.	Зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх мэдээлэл бэлтгэх	3 сая	10 ш постер бэлтгэх	Постерийн бэлтгэж цахим хуудсаар түгээх	2023.05.15-21	ДЭМБ ТЦА
3	НҮБ-аас улс орнуудын төр засаг болон түнш байгууллагуудад “Урьтаж Ухаарах” нь хамгаас чухал гэж уриалж байна.					
3.1.	ЗХАБҮЗ-ийн хуралдааныг зохион байгуулах		ЗХАБҮЗ-ийн хуралдааныг зохион байгуулсан эсэх	ЗХАБҮЗ-ийн хуралдааны холбогдох шийдвэр гарсан байна.	2023.05.19.	ЗХАБҮЗАА
3.2.	ЗХАБҮЗ-ийн тогтоолын төслүүдийг хэлэлцүүлж, батлуулах		Тогтоол/Төлөвлөгөө батлагдсан эсэх	Зөвлөлийн шийдвэрийг батлан, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна	2023.05.19.	ЗХАБҮЗАА
4	Аюулгүй байдлыг хангахын тулд авто замын сүлжээний хамгийн эрсдэлтэй байдлыг харгалзан төлөвлөнө.					
4.1.	Бэлтгэсэн материалуудыг ашиглан мэдээллийн хэрэгслээр төвлөрсөн автобааз бүхий байгууллагад таниулах ажлыг зохион байгуулах		Лекц, яриа, сурталчилгаа хийгдсэн эсэх	Лекц, яриа, сурталчилгаанд зорилтот бүлгийн хүмүүсийг хамруулсан байна.	2023.05.15-21	ЗХАБҮЗАА (ДЭМБ НТГ ТЦА Олон нийтийн байгууллагууд)

4.2.	ЕБС-ийн хүүхдүүдийн дунд “Ногоон гэрэл-цагаан шугам” уламжлалт тэмцээн зохион байгуулах.		Тэмцээн зохион байгуулсан эсэх	Тэмцээн зохион байгуулж ЕБС-ийн хүүхдүүд ЗХД-ийн зохих мэдлэгийг олгосон байна.	2023.05.15-17	ТЦА
4.3.	Хүүхдийг ЗТО-оос урьдчилан сэргийлэх өдөрлөг зохион байгуулах	10 сая	Өдөрлөг зохион байгуулсан эсэх	Сүхбаатарын талбайд өдөрлөг зохион байгуулж, олон нийтийг хамруулсан байна.	2023.05.15-17	ТЦА
4.4.	“Зүрхэнд гэрэлтэнэ” МУСК-ны нээлтийн үйл ажиллагаанд оролцох		Киноны нээлт зохион байгуулсан эсэх	Хүүхдийг ЗТО-оос урьдчилан сэргийлэх чиглэлээр МУСК хийж нийтийн хүртээл болгоно.	2023.05.08.	ЗХАБУЗАА ЦЕГ ТЦА
4.5.	Хүн амын эрүүл мэндэд алхах, дугуй унахын ач холбогдлыг ойлгуулах ба хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах	15 сая	Телевизийн бүрэн нэвтрүүлэг, сайттай хамтран контент, сайт сонинд нийтлэл бэлтгэсэн байх.	Тв, радио, сайтаар бэлтгэсэн нэвтрүүлэг контент хүрсэн байх.	2023.05.15-21	ТЦА (ДЭМБ ЗХАБУЗАА)
5.	Аюулгүй байдлыг хангахын тулд авто замын сүлжээний хамгийн эрсдэлтэй байдлыг харгалзан төлөвлөнө.					
5.1	Улаанбаатар-Дархан, Дархан-Улаанбаатарын автозамд хийсэн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээний тайлан”-г ЗТХЯ-ны ШУТЗ-д танилцуулах, хэлэлцүүлэх		Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээний тайлан бэлтгэсэн байна.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээний тайланг ЗТХЯ-ны ШУТЗ-д танилцуулсан байна.	2023.05.20.	ЗХАБУЗАА
6.	Аюулгүй байдлыг хангасан нөхцөлд алхах, дугуй унах нь хүмүүсийг эрүүлжүүлэх, хотын хөдөлгөөнийг тогтвортой байлгах, нийгмийг тэгш эрхтэй болгоход хувь нэмрээ оруулж чадна.					
6.1	Улаанбаатар хотын хэмжээнд автомашингүй өдрийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана.		Автомашингүй өдөр зохион байгуулах бэлтгэл ажил хангагдсан эсэх	Автомашингүй өдөр зохион байгуулж явган явах, унадаг дугуйгаар явах таатай нөхцлийг бүрдүүлнэ.	202 3.05.21.	ЗХАБУЗАА ХЗДХЯ ЭМЯ НЗДТГ ЦЕГ